

Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны 2023 оны 09 дүгээр сард хийсэн ажлын товч мэдээ

2023 оны 9 дугаар сарын 22

Дархан-Уул аймаг

Тус алба 8 орон тоотойгоор үйл ажиллагаа явуулж, дотоод аудиторын сул 1 орон тоог албаны цахим хуудас болон фейсбүүк хуудсаар мэдээлэхээс гадна Дархан-Уул аймаг дахь Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлд хүргүүлсэн.

Төрийн жинхэнэ албаны гүйцэтгэх албан тушаалтаны тусгай шалгалтад тэнцсэн Нэргүйн Дэлгэрмааг АТГ-т ХАСУМ хянуулан дотоод аудиторын албан тушаалд туршилтын хугацаатай, хүүхэд асрах чөлөөний хугацаа дууссан СХШУБ М.Ганцэцэгийг томилсон.

Аймгийн Засаг даргын баталсан 23-06-23-02/15 дугаар удирдамжийн дагуу Дархан, Шарын гол, Хонгор, Орхон сумын 2021, 2022 оны газрын төлбөр ногдуулалт, төлөлтөд дотоод аудитыг хийж байна.

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газраас ирүүлсэн албан бичгийн дагуу байгууллагын хүүхэд хамгааллын бодлогын талаарх гаргаж хүргүүлээ.

2023 оны 09 дүгээр сарын 08-нд Дархан-Уул аймгийн Засаг даргын Тамгын газраас зохион байгуулсан “Хариуцлага ба харилцаа” лекцэд тус албаны 6 албан хаагч хамрагдлаа.

2023 оны 09 дүгээр сарын 14-ний өдөр Монгол Улсын Ерөнхий сайд тус аймагт ажиллахтай холбогдуулан иргэдтэй уулзах уулзалтад албаны дарга, ахлах мэргэжилтэн оролцлоо.

Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганаар баталсан зарим хууль, Улсын Их Хурлын шийдвэрийг орон нутгийн иргэд, олон нийтэд таниулан сурталчлах арга хэмжээг Монгол Улсын Их Хурлын Тамгын газар, аймгийн ИТХ, ЗДТГ-тай хамтран Залуучууд театрын их танхимд зохион байгуулахад 8 албан хаагч оролцлоо.



Дархан-Уул аймагт зохион байгуулагдаж буй "Соёлын сэргэлт-2023" аяны нээлтийн арга хэмжээнд 5 албан хаагч хамраглаа.



САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН АЛБА